

БОЛДУИН, ДИКСОН, ГЭСКОЙН

Ажил олж өгдөг ажилгүйчүүд

Британид хүн амын 10, түүнээс дээш хувь ажилгүй байх нь энгийн үзэгдэл билээ. Болдуин, Диксон, Гэскойн гурав ч тэдний хэсэг байв. Сэтгэлд таарсан хөдөлмөр эрхлэх найдвар тасарсан нөхөд бусдад ажил олж өгөхөөр шийджээ. Ингээд зуучлалын компани байгуулсан аж. Өнөөдөр Болдуин, Диксон, Гэскойн британий хөдөлмөр зуучлалын хэв шинжит товчоодын нэг юм."Туршлагатай нарийн бичиг яаралтай шаардагдаж байна. Түргэн бичлэгийн мэдлэгтэй, өндөр хурдтай ажилладаг, мэргэжлийн бичээчийг хайж байна. Нэр төрөө эрхэмлэдэг менежер хэрэгтэй, жилд 59.000 паундийн цалинтай, албаны машинтай, оны эцсээр ажлын дүнгээр шагнал олгоно... ийм зарлалыг хөдөлмөрийн агентлагийн цонхноо дүүрэн байхыг үзэж болно.Британий 2600 агентлагийг нэгтгэсэн холбооны дарга Танд Жонсон кадр сонгон олж өгөх нь маш ашигтай, хямд зардалтай бизнес юм гэж мэдэгдэж байна. Тэдний гол зорилго клиент байгууллагуудад тодорхой боловсрол, мэргэжил, туршлагатай хүмүүсийг санал болгоход оршино.Санхүүгийн яам, Хөдөлмөрийн яамны алинаас ч буцалтгүй тусламж, татаас авалгүйгээр тухайн агентлагууд зөвхөн өөрсдийн орлогоор амьдардаг. Ажил эрэгчид янз бүрийн үйлчилгээ үзүүлэвч, нэг ч пенс шаарддаггүй.Үйлчлүүлсэн компаниас л мөнгө авдаг. Уг мөнгөний хэмжээ нь бизнесийн нууц. Шинэ амжилтны жилийн цалин, нэмэлт төлбөр, шагналын нийт дүнгийн 15 хувийг авах нь түгээмэл. Реклам, борлуулалтын хэлтсийн даргын 35 мянган паундийн цалин, албаны машинтай местэнд хүн олж өгсөн бол компаниас наад зах нь 6000 паунд авах жишээтэй.Банк, хөрөнгө оруулалтын фондод дилер, консультант нийлүүлдэг агентлаг маш ирээдүйтэй, 29 настай залууг америкийн банкинд элсүүлжээ. Цаадахи нь жилд 120 мянган паундийн цалин, 100 мянган паундийн шагналтай болох аж. Агентлаг комиссийн 37 мянгыг авсан. Иймэрхүү ашигтай ажиллахын тулд мэдээлэл, чадвар сайтай байх хэрэгтэй нь ойлгомжтой.Хэзээнээс бохир ажиллагаат зарим нь ажил хэрэгчээс гар цайлгахыг шаардвал яах вэ? "Утгагүй хэрэг. Тийм явдал хуулиар хориотой. Үл бүтэх байдлын талаар Хөдөлмөрийн яаманд гомдол мэдүүлэхэд л лиценз хураагдана. Түүнээс гадна нэр хүнд нь унаж, тухайн хүнд нэг ч клиент горилогчийг захиалахаа болино" гэж Жонсон өчиж байна.Орлогын эх үүсвэр нь комисси, зардал нь гэвэл багахан юм. Агентлагт их төлөв хоёр консультант, нарийн бичиг ажиллана. Байрын түрээс, телефон, цахилгаан, шуудангийн зардал нэмэгдээд л гүйцээ.Зарим агентлаг түгээмэл мэргэжлийн түвшинг дээшлүүлэх үнэгүй курс зохион байгуулдаг. Ингэснээр "барааных" нь чанар сайжирч, борлох чадвар нэмэгдэнэ. Гэхдээ агентлаг ажил горилогчийг судлахад гол анхаарлаа хандуулдаг. Компани руу илгээсэн хүний ажил мэргэжлийн үзүүлэлт, намтрын үнэн зөвийг агентлаг толгойгоороо хариуцдаг болохоор чамбай судлахаас аргагүй.Эгэл хүмүүсийн хувьд энэ системийн тусламжийг авах нь тийм ч хэцүү бус. Өөрийн сонирхсои ажилд таарах агентлагийг каталоогоос л олчихно. Нэр, хаяг, утас, факсын дугаар дүүргэсэн тусгай каталогийг Холбооноос нь эрхлэн гаргах агаад, товчоо бүрд худалддаг.Уг лавлахад товчоонуудыг салбараар ангилсан буй. Мөн хичнээн цалинтай ямар ажилд хүн хайж буйг ч тоочсон. Уран бүтээлийн салбарыг нээхэд Болдуин, Диксон, Гэскойн тааралдана. Эл агентлаг дүрслэх урлаг, сценари, найруулга, дизайнаар мэргэшсэн хүмүүсийг сонирхож, их төлөв жилд 12-80 мянган паундийн цалин санал болгоно."Эхэндээ бид туршлагагүй байсан нь үнэн. Яваандаа уран бүтээлийнхний талаар их мэдлэг туршлага хуримтлуулсан. Би уран зохиол, Диксон дүрслэх урлаг, Гэскойн найруулгын чиглэлээр судалдаг. Үүний үндсэн

дээр ямар байгууллагад хэн хэрэгтэйг тодорхойлно. Ухаандаа би сценари юм уу, цуврал ном, эсвэл соины булан бичих хүсэлтэй хүмүүстэй уулздаг. Тэдний давгүй гэж байгаа бүтээлүүдийг нь гүйлгэж харна. Богино зүйл бичүүлж үзнэ. Дараа нь үнэлэлт дүгнэлтээ гаргана. Алдах эрх байхгүй Багахан хугацаанд үүнийг гүйцэтгэх амаргүй шүү. Гэхдээ бид ажлаа гартаа оруулсан" гэж Болдүйн өгүүлж байна.Сүүлийн үед тэд хүрээгээ тэлж, санхүүгийн салбар луу хэлбийжээ. Дэлхийн санхүүгийг том төв Лондоны Ситид ажилтан нийлүүлэх болсон аж. Салбар нь. европын хөгжил, өөрчлөн байгуулалтын банкны удирдах газрын өөдөөс харсан байшинд, швейцарийн 2 банк, японы хөрөнгө оруулалтын фондтой хөрш зэргэлдээ оршино. Уулзахын өмнө заавал цагаа тохирох учиртай. Сити маягаар угтаж, эелдэг бүсгүй цувд тайлахад тусалж, цай кофений алийг сонгохыг асууна. Сэтгэл зовж, сандарсан үйлчлүүлэгчийг тайвшруулах зорилгоор найрсаг байдлыг бүрдүүлнэ. Авьяаслаг атлаа бүрэг номой хүмүүс өөрийгөө таниулж чадахгүй явчих нь буй.Юуны өмнө боловсрол, хаана ажиллаж байсныг асууж, товч намтрыг мэдэж авна. Ямар ажил, цалин хүсч байгаа, хотын аль хэсгийг эрхэмлэхийг мөн лавлана. Хэрэв британий иргэн биш бол, оршин суух эрх, Дотоод явдлын яамнаас авсан хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг үзүүлэх болно. Европын холбооны орны иргэн бол тэгэх шаардлагагүй.Албаны уур амьсгалгүй, чөлөөт ярилцлагаар гэр бүлийн хүн юу хийдэг, хэдэн хүүхэдтэй, тамхи татдаг эсэхийг тодруулна. Олон компани тамхичин хүнийг авахгүй гэж урьдчилан мэдэгдсэн байдаг. Нас, яс үндэс, эрүүл мэндийн талаар асуух хуулиар хориотой. Тэгш эрх, эс ялгаварлах зарчмыг зөрчсөн хэрэг гэж үздэг.Товчооныхон авч буй мэдээллээ нууцална гэдгээ хэд дахин давтана. Ийм учраас ч уулзагчаас намтар, өргөдөл, тодорхойлолт гэхчилэн ямар нэг бичиг цаас огт шаарддаггүй. Одоогийн ажлаа солих гэж яваа хүн үүнийгээ босс маань мэдэг гэж бодохгүй нь лав. Мэдээллийн нууцлал ажил хайгчид тал бүрийн ашигтай. Агентлагууд горилогчийн тухай мэдээлэл солилцож болохгүй агаад, энэ нь эгэл хүний боломжийг нэмэгдүүлж, зохимжтой нөхцөл бүрдүүлнэ.Болдүйн, Диксон, Гэскойны санхүүгийн салбарт гуравхан хүн ажилладаг. Хоёр консультант гол үүргийг гүйцэтгэх агаад нарийн бичиг тусална. Горилогчийн талаар үнэлгээ хийж, ямар албанд тохирохыг ньтогтоогоодтодорхой местүүдийг танилцуулдаг. Ирсэн хүн аль нэгийг нь их төлөв сонгодог. Ингээд тухайн компани руу хүнээ илгээж, цаадуул нь ч хүлээн аваад, товчоо руу хөлсийг шилжүүлнэ. Хүссэн ажлыг нь горилогчид өгч чадаагүй бол, дараа хандахаар утсыг нь авч үлддэг.Зөвхөн түр ажилд зуучилдаг нь ч бий. Рестораны тогооч, тээврийн компаний захиалга ихэдсэнээс жолооч дутах гээд л тохиолдол бишгүй. 3 хоногоос 3 сарын хугацаатай местүүд буй болдог. Зарим овсгоолог хүмүүс түр хугацаанд компанид ойшоогдож, бүр үлдэх нь ч цөөнгүй.Гэхдээ агентлагууд оюуны бичиг сачгийн ажил мэргэжилд л анхаарал хандуулна. Компаниудын захиалгаа ч тийм чиглэлтэй байдаг. Тариа ногоо хураагч юм уу, ачигч авч ажиллуулахад агентлагийн тусламж хэрэггүй нь, мэдээж Заримдаа үйлдвэрийн ажилчны захиалга товчоонд ирнэ. Үүнийг тийм ч тааламжтай хүлээн авдаггүй. Хорин ажлччин цуглуулахад бамкны л менежер олохоос аргаггүй хөдөлмөр зарцуулдаг ч унац бага байх жишээтэй.Нарийн бичиг, түргэн бичээч, худалдааны агент, хуульч, дээд ангиллын зөөгч, асрагч, сайн тогооч зэрэгт байнгын эрэлт хэрэгцээ байдаг аж. Харин ажилчин, багш, сэтгүүлч нарыг захиалах байгууллага ховор.Зарим хүн соиний зарлал харж ажил олох гэдэг. Гэвч энэ нь төдийлөн бүтэлтэй болдоггүй. Байгууллагад хандсан иргэдийн захидал хүссэн хариуг авчрах нь юу л бол. Тэдгээр зарлалыг агентлагуудын мэдээлэлд зориулсан гэлтэй. Дээрх товчоонууд сонирхсон

зарлалынхаа дагуу нэмэлт мэдээлэл авдаг. Тэгээд эгэл хүмүүст ажил олж өгөхөөр үнэн сэтгэлээс зүтгэнэ. Учир нь өөрсдөд нь ашигтай. Байгууллагууд ч агентлагийн санал болгосон хүнийг л эрхэмлэнэ.

МИХАЭЛЬ БОРН

Теле дуулианы мангас

Германы жижиг хот Оберланштайны нэгэн хөлсний байранд ноён Михаэль Борн банан зооглон хэвтэж байлаа. Амьдралынхаа тухай эргэцүүлэн бодоход олигтой дурсамж эс орж ирнэ. Удаан хийж үзсэн ажил нь гэвэл 6 сар гудамжны хөгжимчин, жил гаруй амьтны дэлгүүрийн худалдагч байсан. Урлагийн авьяас нь өдөр бүр пивоны мухлагаар төгсч байв. Харин амьтны дэлгүүр сонирхлыг нь татаж байсан ч, тэжээлийн самар жимснээс ихээхэн гүзээлж, зардал хэтрүүлдгээс хөөгдсөн.33 насыг зооглож, банканд их хэмжээний өр тавьсан Борн цаашид хэрхэх вэ гэдгийг Банантай хамт бодож хэвтсэн нь мэдээж. Гэтэл түүнд бодол төрлөө. Телевизээр, нэгэн сэтгүүлч чухал мэдээлэл бэлтгэж, тухай бүрд 50 мянган марк авдаг тухай өгүүлж байв. Ингээд л Эврика Тэрбээр Борн Ризико хэмээх студи байгуулна гэж эрх авлаа. "Мэргэжлээ" солихыг аймшиггүйгээр хүссэн залуу сэтгүүлч шууд л контрабандистуудын гэмт ертөнцрүү умбан оржээ. Сэтгүүлийн теле хавсралт Шнигель телевизийн редакцийг түүний аз сорьсон үйл ажиллагааных нь үр дүн үг дуугүй байлдан дагуулав. 50 мянгыг хүсэхэд 4500-г өгсөн нь жаахан тиймэрхүү.Германы боомтуудад хууль бус цагаачдыг хэрхэн оруулж буйг сурвалжлагад үзүүлжээ. Яг л кинонд гардаг шиг нүүрсэн дороос пидэн хар албаничууд гарч ирж байв. Хөлдүү загасан дундаас ч халуун зунаар хамаг дах дэгтийг өмссөн оросууд цухуйцгаав. Энэ сурвалжлага олон үзэгчийг цочирдуулав. Гаалийнхан нүүрс, хөлдүү загасыг сайтар шалгах боллоо.Борны ээлжит дуулиан нь зүүн германаас ирдэг хэрцгий дээрэмчдийн тухай байлаа. Сүүлийн үед шуугиан тарьсан хэд хэдэн гэмт хэргийг тэд үйлдсэн юм байх. Барууны ертөнцөд ойлгомжгүй "коммунист" аргаар дээрмээ хийдэг бөгөөд, даруй зүүнрүүгээ явчихдаг тул илэрдэггүй ажээ. Баг өмссөн тэд адал явдлаа сайрхан ярьж, биднийг хэзээ ч барьж чадахгүй болохоор илэн далангүй байгаа юм хэмээцгээв. Дотнын хүмүүстээ мэнд дэвшүүлэх дөхөв. Энэ ярилцлагыг Шнигель телевизийн өрсөлдөгч Штерн телевиз 15 мянгаар авлаа.

Түүнээс гадна Штерн сурвалжлагын зарим зардлыг нь хариуцна хэмээлээ. Удалгүй дэлхийн II дайны үед зүүдэнд оромгүй аймшигт туршлагын гэрч болсон өвгөн нацисттай хийсэн ярилцлагаа авчрав. Амьтан дээр бус, хүн дээр вивисекци туршлага хийдэг нууц лабораторийн тухай өвгөн өчжээ. Хагас зууны өмнө хийсэн шинжилгээний тэмдэглэлүүдээс нь олон гар зургийг үзүүллээ. Ийнхүү Борн Герман орныг нямбайчуудын диваажин бус, дуулианы үүр уурхай болгож хувиргав. Тэр алдар цууг амсав.Хэзээ ч сахлын хутга хүргээгүй арзгар хууз сахал, сармагчин мэт үсэрхэг гар, үлэмж бие, тогоо мэт гүзээ, чанга дуу хоолой, бүдүүлэг үг яриа, ямагт ханхлах тамхи, пиво, хоол, хөлсний үнэр тэрэг нь мань хүнээс нийгмийн дээд давхаргынхан, хадагтай нарыг өөрийн газраас үргээнэ. Харин телевизийнхэн, ялангуяа удирдах албан тушаалтнууд түүнийг харангуут бахдан мишээдэг байлаа. Борн хаалгаар нь шагайна гэдэг тэр өдрийн нэвтрүүлгийг аварна гэсэн үг. Мань хүний материал бол ялааг заан болгох гэж ядагсдын үглэл бус, жинхэнэ баримтат адал явдал юм.Дөрвөн жилийн турш Борн теле үзэгчдийг баясгалаа. Мансууруулах бодис худалдагч, авилгал авагч,

кү клүкс кланыхан, элдэв гаж донтнууд, оргодол рецидивист, террорист, санаанд багтамгүй нууцыг мэдээлэгч гээд л юу эстэй тэр уулзсан гэх вэ. (Олонх нь өөрийгөө далдалж, зарим нь гэгээн дүрээ түмний хүртээл болгоно. Гамбүргийн цагдаагийн газар Борнд талархал илэрхийлэв. сурвалжлагаас санаа авч, Зүүн Германд гэмтнүүдийг хайснаар үи эхээр тэд олсон гэнэ. Дээрмийн бүлгийнхэн таны нэвтрүүлэгт дэндүү буурсан бололтой, шуугиант хэргүүдийн нэгийг л үйлдсэн байна билээ хэмээн нэмж хэлжээ. Энэ нь таагүй байдлын эхлэл болов. Борныг эх сурвалж сайтай гэж үзсэн цагдаагийнхан, янз бүрийн тусгай албаиыхан өөрсөдтэй нь сайн дураар хамтран ажиллахыг тодорхойлон иелдэг бусаар хүсцгээлээ Тэр ч контрабандчин, тийм ч террористын талаар өгөхгүй юм уу, та бодлоо бидэнд ашигтайгаар өөрчлөөгүй л байна уу гэлцэн шаналгана. Мөн ямар нэг хэрэг намдсаны дараа Борн гуай танд дуулсан юм бий юу хэмээнэ. мэдээллийн сурвалжийг нууцлах сэтгүүлчийн эрх л манай хүнийг хоригдохоос аварна. нөгөөтэйгүүр гэмт' хэрэгтнийг дарагдуулахыг буруушаасан зүйл ангиуд айдас төрүүлнэ. Михаэль хэвлэлийн бага хурал хийлгэж, Германд хэвлэлийн эрх чөлөө, ажиллах иөхцөл алга гэж мэдэгдэн. Хайран хүнийг баллачихлаа гэж телевизийхэй хууль сахиулагчдыг зэмлэлээ. Залуу сэтгүүлч маань жилд 500 мянган маркийн цэвэр ашиг олжээ. Гамбургер хийдэг жижиг газар нээж, өөрөө байнга чанар шалгах төдийгүй, үе үе ажилд гар бие оролцоно. Уг нь түүний жинхэнэ авьяас тогоочийн урлагт оршдог мэт. Удалгүй жижиг газар нь дунд газар болж өргөжлөө. Хэн бүхэн түүнийг сэтгүүлчийн ажлыг бүрэн хаясан гэж бодож байтал тиймгүй аж. Германд ажиллахгүй гэснээс бус, гадаадад бол үзүүлж өгөхөд бэлэн байжээ. Тайвширсны дараа мань хүн ахин дэлгэцийн төлөө зүтгэв. Борн бол сэтгүүл зүйн төрөлхийн чадвар гэмээр. Аль л дайн дажин, алаан хядаантай халуун цэг рүү ганцаар одно. Ямар ч дагалдагчаас, оператороос хүртэл татгалзана. Аюул тохиолдвол өөрөө л амь үрэгдсэн нь дээр хэмээнэ. Түнисээс Аджир, Грекээс Серб гээд л зогсоо зайгүй аялна. Хэнд ч ярилцлага өгөхгүй байх үед нь Ясир Арафаттай ч хуучилж амжжээ. Сурвалжлагуудын нэг нь нөгөөгөөсөө сонирхолтой болсоор. Энэ Борны чадварт ер нь хязгаар байна уу. Тэр байнга армийн хувцас өмсөх болсон агаад араб алчуур зангидан, мэдээллийн фронтод дайтна. Питер Арнетт дэргэд нь юу ч биш. Бразилийн наркомануудыг сурвалжилсан нь үзэгчдийн сэтгэлд ихэд хоногшжээ. Аварга бахын бие цагаан дулаар хучигдсан байх агаад түүнийг долоосон мансуучууд дорхноо трансад нэрвэгдэж, камерт анхаарлаа төвлөрүүлэх чадалгүй болох аж. Дөрвөн жилийн сүржигнэл нь Борныг бичил саятан болгожээ. Дуулианы эзэн маань капиталлаа тансаг амьдралд эс үрнэ. Оберланштайндаа өөрөө нэг урц байсныг эс тооцвол амьжиргааны түвшин нь үзэгдэхүйц дээшлээгүй. Харин хүнсний салбарт хөрөнгө оруулалт хийснээр орлогоо гомдолгүй өсгөж байв. Дэлхийн сенсацийг таниулаад дууссан бололтой. Тини сувгуудыг баясгахаан ч байв. Борныг бишрэгч идэр сэтгүүлчид сонирхолтой материал авчирдаг болсон тул телевизүүд түүнийг үгүйлэх нь багассан. Гайтай цагдаа нар л Михаэльд түвэг уджээ. Наркотик дамладгаа ичгүүргүй тайлагнаж суусан багтай эрхэм тэдэнд нэг л танил санагдав. Судлаад үзвээс уг этгээд жилийн өмнө герман кү клүкс кланыг үндэслэгч болохоо нотолж байжээ. Телевизийн эл хоёр сурвалжлагыг хуучин танил Борн нь хийсэн байв. Тэгэхлээр цаанаа ул үндэстэй гэсэн үг. Шерлок Холмсын арга мэхээр бүр ч лавшруулан шинжсэн чинь Гюнтер Шүстер болох нь тодорлоо. Тэр бол наркомафиозо ч биш, расист ч биш, зүгээр л салгалан тэнэж явдаг, орон гэргүй мансуурагч. Цагдаа нарыг очиход тэр сүүмийсэн нүдээр гөлийж "Борн оо, ахиад нэг ярилцлага хийцгээе, 500 марк

өгчих" гэжээ. Ингээд л супер сэтгүүлчийн үнэн түүх ил болох нь тэр. Шүстер хэдэн маркийн бараа харвал Германы канцлерийн дүрд тоглохоос ч буцадаггүй аж. Борн хэлэх үгийг нь бичиж өгдөг, цаадахь нь зүгээр л уншчихдаг байжээ. Манай хүн архичин тамхичнаас бүрдсэн бүхэл бүтэн сайн дурын уран сайхны хамтлаг байгуулсан юмсанж. Тэд л дөмөг хямд хөлсөөр Борны найруулсан жүжигт тоглодог байжээ. Удирдагчдаа муугүй ханддаг тэд нууцыг задруулахыг хүсээгүй. Ингээд л 4 жил хөгжилтэй "театралууд" улс орон даяар бужигнуулсан ажээ. Онцгой драматик авьяас шаардах дүрүүдэд Борн өөрөө тоглохоос буцаагүй. Зарим супер хитүүддээ видеомонтаж ашигласныг нь дурдах хэрэгтэй. Бах л жинхэнэ байсан бөгөөд харин мансуурах бодис нь хуурамч, ердөө л жирийн сүү байлаа. Хэд хэдэн ноцтой зүйл ангиар Борнд эрүү үүсгэн шалгав. Энэ удаад Михаэль өөрөө дуулиант сурвалжлагын объект боллоо. Өмгөөлөгч өөрийнх нь үйлчлүүлэгчид сайн талууд буйг дурдав. 1-рт Борн худал хуурмагийн нүгэлээ ухаарч, дахин тийм зүйл хийхээ болиод удаж буй гэнэ. 2-рт, хурц асуудлуудад нийгмийн анхаарлыг хандуулж чадсан аж. Ингэхлээр ял нь тэнсэн харгалзах хувилбарт шилжихээс өөр яах билээ. Өдгөө Борн жижиг хотдоо дунд бизнес эрхлэн, амар сайхандаа жарган суугаа билээ.

ВЛАДИМИР БРЫНЦАЛОВ

Бухнийг ашиг болгож хувиргана

1946 онд Оросын Ставрополь хотын Черкеск хотод, Брынцаловын гэр бүлд Владимир хүү төржээ. Түүний эргэн тойронд казакууд болон черкесүүд аж төрнө. Аль аль нь л аж ахуйч, ажил хэрэгч, шийдэмгий, сэргэлэн хүмүүс. Тэр ч бүү хэл, энэ хоёр угсаатныхан хоорондоо өрсөлдөнө. Казакууд нь черкесээс дор орохгүй хэмээхэд, черкесүүд нь булаан эзлэгч казакуудын дээр гарах учиртай гэнэ. Брынцаловынхан хотоос зайдуу зусландаа жимс, ногоо тарьдаг нь зугаа төдий байв. Харин Владимир дунд сургуулийн сурагч байхдаа л зугааг илүү үр дүнтэй болгох аргыг ажиж мэдэн. Тэрбээр хаягдсан модон шүүгээг ашиглан зөгийн үүр бэлджээ. Ингээд дампуу ажилтай нэгэн Колхозоос бүл зөгий хулгайлан авчран. Эцэг нь "Өвөг дээдэс маань морь л хулгайлдаг байсан. Чи тэднийг давж гарлаа. Сайн казак болох нь" гэж өхөөрдөв. Хүмүүст зөгийн бал хэрэгтэй ч тэр нь дэлгүүрт ч, эмийн санд ч байдаггүй байна. Эхний зун хүү сургуулийн зардлаа дааж, унадаг дугуй аваад зогсолгүй орон гэрээ ивээн тэтгэв. Намар хүү хотруу явахгүй, зуслиадаа үлдэнэ, тосгоны сургуульд орно гэхэд нь эцэг эх хичнээн гайхсан гээ. Аз болж, эмээ нь мөн эрүүл агаарт баймаар байна гэж. Ингэж хүү зөгийчин болжээ. Тэрбээр эм зүйч болохыг хүссэн ч, хуваарь олдоогүй тул уулын инженерийн ангийг 1969 онд төгсгөв. 1973 онд алслагдсан колхозын хүрээнд Пчёлка хоршооллоо байгуулав. Зөгийн бал, цөцгий үйлдвэрлэж, яггүй ашигтай ажилласан ч, хамаг орлогоо өөртөө үлдээж дөнгөнө. Энэ нь хээл хахуулийн үр дүн байлаа. Социализмын үед Зөвлөлтөд далд капитализм, нууц саятнууд, сүүдрийн эдийн засаг байсан. Тэдний эгнээнд Брынцалов эргэлзэлгүй элсэв. Хүн шударга хөдөлмөрлөж, түүнийхээ үр шимээр сайхан амьдрах нь буруу биш гэж баттай итгэсэн байв. Гэхдээ бараг л хувьсгалт нууц бүлгэм шиг нөхцөлд ажиллаж байлаа. Хэзээ ч толгой дээр нь аянга ниргэж, 20-иос багагүй жилийн ял авч болно. Үнэндээ тэр зөвлөлт засгийн эсрэг үзэлтэн болсон байв. Сайтар судалж байж, коммунист бус бодолтнуудыг цуглуулан хоршоондоо авч ажиллуулна. Тэднийгээ алдчихгүй, урвуулчихгүйн тулд байнга хөрөнгөтний суртал ухуулга хийнэ. Аймшгийн 12 жил өнгөрч, 1985 онд өөрчлөн байгуулалт эхэлж, аливаа хувийн өмч, чөлөөт хөдөлмөрийг хүлээн зөвшөөрлөө.

Эртнээс капитал хуримтлуулсан байсан Брынцалов анхны кооперативчдын нэг боллоо. Хэд хэдэн сүйрэх дөхсөн газруудыг худалдан авлаа. Анхдагч учраас түүнд давуу тал байв. Өөрийн бүтээгдэхүүнийг эцэст нь хүртэл боловсруулах нь хэрэгтэй гээд эмийн үйлдвэр, сүүн завод, архины цех зэрэг 10 нэгж шинээр байгуулав. Рекетирүүдтэй тэмцэх зорилгоор зоригт хөвгүүдийг цуглуулснаар өөрөө бараг мафийн толгойлогчирхуу болчихов.Тал нь намаг, үлдсэн хэсэг нь чулуугаар дүүрсэн, бас хорт могой элбэгтэй уужим зэлүүд газар байдаг байв. Түүнийг Брынцалов хямд үнээр авчээ. Намгийн шавраар хөрс сайжруулалт, бордоо хийж, чулуугаар хашаа байшин барьж, хорт могойг цуглуулан тусгай ферм бариулж, эцэст нь бас асар их хэмжээний тэгш сайхан газартай болжээ. Тэр газартаа эмийн ургамал тариалбал ашигтай гэж үзсэн нь онолоо.1989 онд Москва мужийн Электрогорск хотын эмийн үйлдвэрийг худалдан аваад, нурааж хаяхад нь хэн бүхэн гайхав. Оронд нь эм-химийн асар том комбинат бариулж, америкийн төхөөрөмжөөр тоноглолоо. Буй болсон 5 мянган ажлын байр мөхөлд унасан хотын насанд хүрэгчдийн тэн хагасыг хөдөлмөртэй залгуулав. Агробио-Апис гэдэг хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулж, олон нэгж нэмж үүсгэснээр удалгүй хот бүхэлдээ түүний мэдэлд орлоо. Хамгийн сөнөмөл хот хамгийн цэцэглэсэн газар болж хувирав.Орост шилжилтийн хүнд бэрх цаг үе эхэлсэн агаад эмийн салбарынхан бүгд л Брынцалов биднийг авраасай гэж байв. Үнэхээр ч Владимир зогссон үйлдвэр, лабораториудыг ээлж дараалан худалдаж авсаар байлаа. Ихэнхийг нь үнэгүй авсан гэхэд болох юм. тэрбээр үйлдвэрийг ажиллуулсныхаа дараа ашгаар нь авсан үнээ төлнө гэж тохиролцож чаддаг л байв.1992 онд хувь нийлүүлсэн Ферейн нийгэмлэгийг байгуулж, нсфтийн мангасуудтай эн зэрэгцэм аварга байгууллага гарч ирэв. Дашрамд Ферейн нефтьтэй ихээхэн холбоотой. Нефтехимийн том үйлдвэрүүд Ферейнд буй.Эдийн засгийн хямралаас болж, улсын эмийн аж үйлдвэр бүрэн дампуурсан. Зах зээлийн хоосон орон зайг Брындалов асар их хүч чармайлт гаргаж, шууд утгаар шургаж унатлаа ажиллаж байж нөхөж чадсан. Тэр Ферейний бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдвэрлэхийн эсрэг тэмцэлд орлогынхоо 40 хувийг хүртэл зориулж авсан удаатай. Ферейнчүүд үүнд дэндүү их мөнгө зарж байна гэж шүүмжилж байсан ч гэлээ, Брынцалов байр суурь дээрээ туйлбартай зогсов. Удалгүй ард түмэнд зөвхөн Ферейний эм тариа л хуурамч бус байдаг гэсэн ойлголт төрж, гүйлгээ олон дахин нэмэгдлээ.Сурталчилгааны ач тусыг эрт ойлгосон хүн бол тэр юм. Гэхдээ гадаадынхан шиг нэг үрэл амандаа хийнгүүт л үхлийн өвчнөөс салж буйг харуулсан клип хийлгэдэггүй байлаа. Өөрөө л ярьж орхидог байв. Би ийм эм үйлдвэрлэж байгаа, тийм тийм давуу асуудал гарвал надтай л хариуцлага тооцох хэрэгтэй, оросын үйдвэрлэлээ дэмжээрэй, оросууд бид бүхнийг чадна шүү гээд л ярьдаг байв. Энэ нь олон түмэнд таалагдсан.Одоо түүний үйлдвэрлэлийн цогцолборт 100 мянган хүн ажилладаг. Ажиллагсдын дундаж цалин 700, хамгийн бага цалин 120 доллар. Эм зүйч, Эша,эрдэмтэд10 мянга хүргэж ч авна. Брынцалонын эмийн ват улсад жилд 10 тэрбум үрлэн эм, гурван тэр бум тариа үйлдвэрлэж байна. Эмийн салбарт Оросдоо Брынцалоктой өрсөлдөх хэн ч байхгүй юм.Бусад салбарт л гэхээс. Учир нь, Владимир мөн банк, даатгалын газар, химийн фабрикууд, ХАА-н нэгжүүд, архины үйлдвэрүүдтэй. Москва мужийн бүх архины үйлдвэрийг худалдаж ансан хүн гээд бод. Тэр Брынцалоив нэртэй архи, коньяк, дарс гаргасан. Яагаад гэвэл архины салбарыг их ирээдүйтэй гэж үзэж буй. Өдгөө Брынцалок архи улсдаа хамгийн цэвэр гэж алдаршаад байгаа. Тэрбээр архи хийхдээ эмийн адил үзэж, дэндүү түвэгтэй технологиор боловсруулдаг.Москвагийн Нагатинская 2-д олон давхар, ендөр хөх барилга Брынцаловын амжилтын бэлгэдэл болон сүндэрлэж

буй. Оройд нь Ферейн гэсэн тод улаан гэрлэн чимэг дурайна. Гэвч энэ нь Брынцаловт хангалттай бус. Орос дахь эдийн засаг, зах зээлийн бодлого, таваар мөнгөний харилцааг тэр их шүүмжилдэг хүн. Тиймээс 1996 онд улс төрлүү орж, Оросын социалист намыг байгуулсан. Нэрээ ОХУ-ын ерөнхийлөгчид дэвшүүлж багагүй санал авсан. Өөрөөс нь хорь дүү, ухаантай үзэсгэлэнт бүсгүй болох гэргий Натальягаач Төрийн Думд дэвшүүлж байсан юм. Түүний араас бизнесийнхэн эрх ашгаа хамгаалахын тулд улс төр лүү хошуурсан билээ. Оросын тэргүүн баячуудын нэг Брынцалов ийнхүү бүхнийг ашиг болгон хувиргаж чаддаг чанараараа амжилтад хүрчээ.

БЪЕРМАНН, ВАТИНАБЭ, ПОЛХЕМУС

Хогийг хөрөнгө болгосон нь

Жараад оронд хог новшны асуудал хурцдаагүй байлаа. Бөөгнүүлээд л нэг хонхорт хаячихна, тэгээд гүйцээ. Шведийн Финспонг гэдэг жижиг хотын ган хайлуулагч Челл Бьерманн өөрөө сэтгэжээ. "Байгаль орчныг сүйтгэгч хогийг багасгах хэрэгтэй, гэхдээ ашигтайгаар" гэж бодов. Шил, хуванцар, металл сантай зүйлийг худалдахдаа 5 центийн барьцаа авч бай гэсэн байна. Саваа өгөөд 5 центээ эргүүлж авч болох аж. Гэвч түүнд хүн үгүй. Хамаг барааны үнэ 5 центээр нэмэгдсэн мэт л хүлээн авцгаажээ. Хэн ч буцааж тушаахгүй байх. Хотын гудамж талбай хогонд дарагдсаар. Харин ажилгүй эр Ги Полхемүс Үй Кэн буюу "Бид чадна" компанийг байгуулж, сан цуглуулж эхэлжээ. Тэрбээр гэр бүлийн хамт нэг жилийн турш түүсэн санаа 12 мянган долараар тушаасан дүн гарчээ. Дараагийн жил 500 мянга, гурав дахь жилээ 800 мянган доллар оллоо. Энэ бүх шил Полхемүсийн гэр бүл, хамаатнууд л цуглуулсан юм. Түүнээс бусад нь биелүүлэхгүй байгаа тул хууль хүчингүй болох төлөвтэй. Ингэснээр Үй Кэн дампуурна гэсэн үг биш. Штатын засгийн газрын дэмжлэгтэйгээр би элдэв савыг хайлуулж боловсруулах үйлдвэр байгуулжээ. Ийнхүү улсдаа анхдагчдын нэг боллоо. Америк бол жинхэнэ хогны орон юм. Эгэл америк хүн хөгжингүй орны нэг иргэнээс 2-3 дахин их хог хаядаг. Хог боловсруулна гэж санах ч үгүй. Байнга сольдог автомашинуудыг нь хүртэл дээр дээрээс нь овоолоод орхисон байдаг. Экологийн үзэл 1 санааг саяхан болтол коммунист сурталтай адилтгаж байв. Өнөөдөр л Америк бага сага ухаарч буй. Тийм болохоор Ги мэтийн хувьд гэрэлт ирээдүй хогон дундаас мишээх төлөвтэй. Японы Кансай Носака аль дивангалавт америкийн новштой хутгалдсан хүн юм. Тэрбээр сар бүр АНУ-ыг зорьж, хөдөөгийн штатуудаар хэсэн, тавь жараад оны эд юмс цуглуулдаг. Оймсноос хөргөгч хүртэл юу л бол юуг хамж ирнэ. Чингээд Токиогийн Харазюкү гудамжнаа орших хуучны зүйлсийн захдээр зарна. Бараг үнэгүй олж ирсэн бараа нь жилд 72 сая ен буюу 540 мянган долларыг эзэндээ авчирдаг. Үүний дэргэд замын зардал, буудлын үнэ, гаалийн татвар, захын хураамж юу ч биш байдаг гэнэ. Пепси колагийн 1957 оны лааз 38 мянган ен, хуучны Женерал электрик хөргөгч 250 мянган ен, балар эртний тоос сорогч Гүвер 60 мянган ен гээд энд байж байна. Хамгийн хямд бараа нь дээр үеийн өндөгний хайрцаг 480 ен. Тэр харагдаж байгаа өнгөрсөн зууны хиймэл цэцгийн баглаа 10 мянган ен. Япончууд хуучны зүйлийг их сонирхдог. Энэ хоббигоо ваби саби гэнэ. Байнгын үйлчлүүлэгчид нь Носакад сар бүр (0-15 мянган ен буюу 75-100 доллар үлдээгээд явна. Дашрамд, нихончуудын дундаж цалин 300 мянган ен юм. Каразюкүд америкчууд ч хааяа нэг үзэгдэнэ. Үрэлгэн жуулчид үнэ буулгана гэхгүйгээр авахад бэлэн байдаг. Гэхдээ төдөн цент ч гэх юм уу, 1 - 3 доллар гэсэн эртний үнэ нь бичээстэй байвал маш их уурлаж "дамчин минь,

хариад үнэгүй олоод авчихаж чадна" гэдэг аж. Харин Носака инээмсэглээд л зогсч байна. Түүнд сэтгэл хангалуун байх үндэс буй билээ.

ЛАРС ВИНДХОРСТ

Тоглоом тоотной нь дээр

Ларс Виндхорст гэсэн үгийг сонсоод л германы улс төрчид өхөөрдөж гардаг байв. Эдийн засгийн сайд, парламентын дарга, камцлер бүгдээрээ л инээмсэглэлээ барьж үл чадан, эцгийн бахархлаар халгиж цалгина. Энэ Ларсад тэгээд ямар гарамгай зүйл байгаа юм бэ? Германчуудыг бишрүүлэх нь тийм амархан гэж үү. Амар ч биш ээ. Залуу ноёнтон Виндхорст 7 оронд хоёр холдинг, хорин охин пүүс эзэмшиж байв. Тэр хоёр жилийн дотор 100 мянган маркийг 80 сая болгон хувиргасан юм. Ларсын гол зорилго нь гэвэл германы эдийн засгийн өмнө Азийн цэцэглэн дэвжиж буй зах зээл рүү зам тавьж өгөх явдал. Нутгийн онцлогийг мэддэггүй, европын ихэмсэг зантайгаасаа болж, хойдын бизнесменүүдийн хүрч чаддаггүй тэр газар луу. Өөрийнх нь тусламжгүйгээр арабын элсэнд Порше хөдөлж чадахгүй гэж сэтгэсэн цорын ганц бизнесч нь Ларс Виндхорст биш ээ гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Эсвэл бүгчим Сайгоныхон хүйтэн герман пивогүйгээр ангаж хатна ч гэдэг юм уу. Хэргийн гол нь сэтгэлгээний шинэлэгт байгаагүй юм.

Ларс хүү Вүндеркинд байсанд л гайхамшиг оршино. Тэр 16хүрэв үү үгүй юу л орчлонгийн өнцөг булан бүрт цацсан пүүсүүдээ төрүүлж эхэлсэн.Германы багачууд дунд сургуульд 7-гоос 20 нас хүртлээ 13жил суралцаагийг анхаарч үзэгтүн. Дараа нь хэдэн жил бензин түүгүүр кафе маркетад зүтгэнэ. 25 насандаа их сургуульд элсэх бэлтгэлээ хангахын тулд. Товчхон хэлэхэд энэ орны том бизнесчдийн дундаж нас Брежневийн УТТ-ынхны дундажтай адил билээ Е р иь залуу үеийнхэн нь олон түмний санаа бодолд ажилгүйдэл гэмт хэрэг зэрэг үгнүүдтэй хөрш зэргэлдээ оршино.Ноён Коль яахин түүнийг өхөөрдөхгүй байх билээ. Канцлер уяран догдлож, наранд цөцгийн тос зөөлрөх шиг л хайлж эхлэв. түүний зуслангийн харшдаа урьж, удтал ярилцан, амралтын өдрийг хамт өнгөрүүлсэн. "18 настнууд маань тэтгэмжийн тухай биш, аз барьж дэлхийг дагуулах тухай бодож байгаасай гэж би ямагт мөрөөдөж ирсэнсэн" гэж канцлер маань сэтгүүлчдэд хэдэнтээ давтжээ. Тамхимы Реемтсма концерий удирдагч Людгер Штаби "Зөвхөн хогжим, теннист тоглохын авьяас байдаггүй юм" гээд Ларсын гарыг атга удтал сэгсрэв. Бүгд л манай германы Билл Гейтс бяцхаи Ларс мандтугаи гэж байлаа.Яагаад Ларс хар багаасаа бизиесийн ертөнцийг буурь суурьтай сонирхож эхэлсэн нь оньсого билээ. Нэг л өдөр ангийн багш нь Ларс хичээл дээр өөр юм уншаад сууж байдаг хэмээн эцэг эх Виндхорстод айлтгажээ. Ларсын ангийн хүүхдүүд ч комикс, эротик сэтгүүл эргүүлжл байдаг. Гавч манай хүн болохоор биржийн хэвлэлүүдийг уншдаг байж гэнэ. Аав ээж нь гаж сонирхолд нь түгшиж, уг зүйлийг тас хорив. Удалгүй хүү нь гитар тоглож сурч байгааг мэдээд тайвширчээ. Харин дэмий тайвширч.16 хүрэхдээ хүү хоёр бэлэг хүсчээ. 1-рт, сургуулиа хаяхыг зөвшөөрөх, 2-рт, 100 мянган маркийн зээл олж өгөхийг хүссэн байна. Ам алдсан эцэг яаж ч чадсангүй. Хий л мөрөө хавчив. Хүү Виндхорст тэр дороо үнэтэй оёдолчинд костюм захиалж, алтан цаг авч, торгон зангиа зүүж, дээд ангиллын лимүзинийг жолоочтой нь хөлслөх нь тэр. Зээлийн буман марк хязгааргүй цэцэглэлтийн гараа боллоо.Жил ч болоогүй байхад албан ёсны статистик сэргэлэн хүүгийн байгуулсан хэдэн арван пүүсийн нэрээр нэмэгдэв. Харин Гамбүргийн хэвлэл шидэт хүүхдийн тухай мэдээллээр баяжлаа. Арийн Гейтс ажиллалаа. Гонконг, Герман дахь хоёр холдингдолоон оронд хорин салбартай болов.Мөөг ургах адил

бага оврын УЦС -иуд баригдаж байв. Германы бараа цуваа цуваагаар Вьетнам, Гонконг, Хятадыг зорино. Азийн хүнд суртлын дарлал мөлжлөг байсан ч, пиво, ёгурт үйлдвэрлэх европын үнэт технологиуд тэнд цэцэглэж, үр ашгаа өгч эхэллээ. Энэ бүхний араас германы хөдөө нутгийн жаалхүүгийн жаргалтай инээмсэглэл салахгүй дагана. Тэрбээр хятадын бизнесчид Боннд айлчлахад, канцлер Бээжинд морилоход замчлан явжээ.Түүний хөрөнгө оруулалтын төслүүд дотор нэр төртэй хүмүүс, компаниуд байр сууриа эзэлсэн байв. Автомашинны аварга Порше, санхүүгийн дээдэс Саль Оппенгеймер, германы гадаад бодлогын уран барилгач Ханс Дитрих Геншер гээд л бүгд төсөлд дурдагдсан.Сайгоны төвд 200 м өндөр цамхаг бариулж, ажил хэргийн зүрх болгоно хэмээсэн төсөл ч байлаа. 1998 онд ашиглалтал орох ёстой эл цамхагт нэр бодож олох гэж зовсон ч үгүй, шууд л Виндхорст Тауэр.Гэвч саятан жаалхүү эцэг эхнйинхээ гэрт, дээврийн дорхи "тагтаны үүрэнд" амьдарсаар байв. Мөн Гонконгийн бааруудад

пэлээд цагийг өнгөрөөнө. Түүнээс гурав дахин ах ажил хэргийн түншүүд нь эвгүйцсэн хэвээр л байсан. Өхөөрдөм хүүгийн толгойг илчихгүйн тулд тэд бүх л чадлаараа биеэ барьж байлаа. Залуу суутны сурагч төрх арилшгүй аж. Цээжилсэн тодорхойлолт дуржигнуулах адил тод агаад түгдрэлгүй ярьдаг нь ч тэр л хэвээрээ.Гонконгийн ажил хэргийн төвд байдаг Ларсын товчоо аймшигт үнэтэй байлаа. Сард 40 000 марк төлөн сууна. Даруухан Ларс зогсолтгүй инээмсэглэсээр 1994 онд 80 сая долларын эргэлт хийжээ. Баримт ёсоор бол 1996 онд 300 сая долларын эргэлт хийх сетой байв.Орлого арифметик прогрессоор, алдар геометр прогрессоор өсч байсан тэр гэрэлт цаг үед Виндхорст алсын хараагүй шийдвэр гаргажээ. Алдааг нь байнга сануулах болсон менежер Хорст феттерийгээ халсан байна. Тэр алдаа нь гэвэл бяцхан хөвүүн ердөө машин хийж байсанд оршино. Бизнесийн оргилд хүрэх герман машин дэндүү урт замналыг товчлохын тулд тэр бүхнийг залилчихжээ. Гомдсон Феттер гэр лүүгээ ч юм уу, хөдөлмөрийн биржрүү биш, нийт Германы хэвлэлийн нийслэл Гамбүргрүү явжээ. Грманы хамгийн их уншигддаг 7 хоног тутмын сэтгүүл Шпигель, Штерн хоёрын сурвалжлагч нартай уулзжээ.Сэтгүүлчид гонконгийн холдингийн бичиг баримтыг сонирхож эхлэв. Анхны олз гэвэл банкны квитанци байлаа. Ларсын арван чекийг төлбөрт хүлээн аваагүй аж. 2-53 мянган маркийн өчнөөн олон нэхэмжлэх Виндхорст дээр овоорсныг илрүүлэв. телефоны пүүс 10.000 маркаар ярьсныгаа мартчихаагүй биз гэж сануулжээ. Сард 4600 маркаар түрээсэлсэн Мерседес 600—гийнхаа хувь заяаг автопрокат 4 дэх удаагаа сонирхсон аж. Бизнес төвийн зохицуулагч 30 ам метр офисын хөлс 200 мянган маркийг яаж олж авахаа мэдэхгүйгүй болсон. Гонконгийн амьдардаг байрных нь эзэн сар бүр түүнээс 11.000 марк нэхсээр залхаж, сүүлдээ цагдаагийн газар ханджээ. Бичиг хэргийн пүүс факс, ширээ, бусад элдэв шидийн зүйл түрээслүүлсэн боловч, сарын 100 маркаа нэг ч удаа Ларсын гарт олж хараагүй байна. гэтэл Ларс чухам мөнгөний хэргээ л онцгой гялалзуулж байсан гэдэг шүү дээ. Ахимаг түншүүддээ би төлбөрийн салбарт хувьсал хийж байгаа гэж дахин дахин сайрхдаг байжээ. Түүний яриагаар бол нэг ч пүүст нь микроскопын хэмжээнд ч төлбөрийн асуудал байх ёсгүй гэнэ. Виндхорст группийн 20 компанийн бүх санхүүгийн мэдээлэл хуруу инчдэхэд л компьютерийн дэлгэцнээ гарч ирнэ. Асуудал байлаа гэхэд шеф мөн л хуруу хөдөлгөөд л бэлнээр мөнгө шилжүүлчихнэ. Уг нь хамгийн гол нь шилжүүлэхийн тулд мөнгө өөрөө байх ёстой. Сэтгүүлчдийн 11 дайралтын дараа Виндхорстын түншүүдийн сүүлчийн найдвар унтран. Урьд дурьдсан бүх гайхамшиг уйлах инээхийн аль аль нь багадаа тийм нэг залилан байжээ.Хамгийн түрүүнд эрчим хүчний аварга

коицерн Феба алмайран гайхан. Ларс тус концернд 3 тэрбум марк эргэлтэд оруулахад нь "тусалж", Хятадад Фебагаар 3 УЦС, 2 ДЦС бариулах гэж байгаа гэдгийг нь дуулаад тэр шүү. 1 -рт, Виндхорст өөрийнхөө тухай танилцуулснаар л Феба хоёрын хамтын ажиллагаа гүйцэж байв. 2-рт, Хятадад цахилгаан станц барих ажил Фебагийн ямар ч хөтөлбөрт ороогүй аж. Виндхорст Поршегийн лидертэй I мин л ярилцсан юм байна. Нөгөөдөх нь нэгэн хүү амжилтаараа сайрхсаныг л бүдэг бадаг саналаа. Ларс автомашин үйлдвэрлэгч энэ том пүүст Хятадад нэвтрэх замыг нээж өгснөө мэдэгдсэнийг уншаад Поршегийн босс золтой л сандлаасаа ойчсонгүй. Баден Виртембергийн ерөнхий сайд асан, Еноптик пүүсийн удирдагч Лотар Шнетийн хувьд гэвэл Ларс ердөө л нэг удаа Иегүди Менүхиний концерт дээр түүнтэй дайралджээ. Ханс Дитрих Геншерийн барааг нь ч харж байсангүй. Ийм л байдал Ларсад, хамтран ажиллахыг зөвшөөрсөн, ажиллаж байгаа гэхчилэн мэдэгдэхэд саад болсонгүй. кино үйлдвэрлэгч Георг Раум Азид пиво исгэх газар, ёгуртийн фабрик барих олон захиалга олж авахын төлөө Ларсад шаггүй хөрөнгөө итгэжээ. Гэвч 10 сар өнгөрөхөд Ларсын супер мэргэжилтэй агентууд нэг ч захиалга олж чадаагүйг сонсоод амаа барив. Нэг ч агент үнэндээ байгаагүй хэрэг. Ёрг Котлевски бүх Хятадыг Вьетнамтай хамт автомашин цэвэрлэх хэрэгслээрээ дүүргэнэ гэж итгээд хамгийн аз жаргалтай байв. Виндхорст сард 20.000 маркийн хөлсөөр бүтээгдэхүүнийг нь вагон вагоноор борлуулна гэж амлажээ. Хэдэн сар хүлээсний лост Котлевски эелдэг бус захидлуудаар бөмбөгдөж, Виндхорст дуртай дургүй 1 контейнер захиалжээ. Гэхдээ төлбөрийн ямар ч баталгаа гаргаж өгөөгүй. Сайгон дахь 200м өндөр барилга ч Виндхорст гэгдэх нь өнгөрлөө. Ларс хотын захиргаанаас барилгын зөвшөөрөл аваагүй нь мэдээж. Тэр бизнесмен болж тогложээ. Тоглоом нь тэгээд илэрчээ. ЭЦГ хахууль, хөрөнгө оруулагчдыг мэхэлсэн, итгэлийг хөсөрдүүлсэн зэрэг зүйл ангиар Ларсыг татахаар материал цуглууллаа. Гэвч германчууд "Ларс Виндхорст" гээч сайхан домгийг 14 хоногт л үнс нурам болгосон сэтгүүлчдийг нэг их сайшаасангүй. Энэ домогт итгэхийг л хүсч байлаа. Хаа сайгүй л итгэхийг хүсч байв. Германд, Хятадад, Гонконгод, Вьетнамд, аль алинд нь. Итгэхийг хүссэн учраас л Хятад Ларсын амласан хөнгөн тэргийн үйлдвэрийг Поршегоос нэхжээ. Порше ч сохорсон биш, завшив гээч юм болов. Ларсын гэрээлсэн барилгуудыг босгохоор германы компаниуд Азийг зорилоо. Ларсын бараг төсөл бүрд сайн дурын хэрэгжүүлэгчид олдов. Харин Ларс Виндхорст 80 сая маркаа аваад ор сураггүй алга болжээ. Уг нь тэр мөнгө зуучилсны шударга хөлс байж бүрэн болохоор. Сүүлийн үеийн мэдээгээр бол, ертөнцийн луйварчид цугладаг Израильд бужигнуулж яваа сурагтай.

ВОЛГИН БА БУСАД

Орчин үеийн Брүтүүд

Семён хүү дипломат бэлтгэдэг алдарт МГИМО-д онц сайн дүнтэй суралцан төгссөн нь 1980 он. Африкийн Нигери улсад томилогдсондоо жаахан дурамжхан байлаа. Онц сурлагатан, мэргэжлийн дипломоос гадна англи, франц хэлний орчуулагчийн диплом, дээд зэргийн тодорхойлолт, шил толь шиг намтартай хүнийг ядаж Финланд руу илгээчихгүй дээ. Тэрбээр нам засгийн даалгавраа л биелүүлж байвал үхсэн ч яахав гэж боддоггүй байлаа. Өрнийн ертөнцийг ул суурьтай судалсан, АНУ-д дадлага хийсэн зэрэг нь түүнийг огт өөр бодолтон болгожээ. Барууныхан шиг л баян чинээлэг амьдрахгүй юм бол хэрэг

алга гэж дотроо санана. Африкийн хамгийн том улсад гадаадын мэргэжилтнүүд олон байлаа. Английн харъяат Гордон Каррэнтай тохиолдлоор танилцсан байна. Гэвч тэдний гэрт аяга цай уухаар, дараа нь нэг хундага юм амсахаар очсон нь тохиолдлоор ч арай биш байлгүй. Уг нь тэдний охин, маш сэтгэл булаам ховорхон бүсгүй Викториад татагдсан болох нь ч мэдээж л дээ. Вика ч түүнд найртайгаар хандах нь үлгэр домог мэт гайхамшигтай санагдана. Гэвч нэг л өдөр тэр бүсгүй алга болчихжээ. Оронд нь үлэмж биетэй, маш шингэн үстэй, бараг өнгөгүй нүдтэй ноён Грин гээч аймшигт этгээд буй болов. "Залуу минь, бодит байдалдаа буун ирж үз. Барууныхантай үерхэн нөхөрлөх явдлыг тань КГБ таашаахгүй байна. Даруй үлгэр жишээ зөвлөлтийн иргэн болж хувир. Тэгээд бидэнтэй хамтран ажиллавал дээр. Таныг бид эртнээс судалсан. Ялимгүй мэдээлэл өгч байх юм бол зүүдэнд тань ч орж байгаагүй урамшууллыг олгоно гэж мэд. Тусалсан хүнийг бид Америкруу татаж чадна. Тэр үед л ямар ч Викториагаар учрахад эрх чөлөөтэй болно доо" хэмээв. Гэтэл Семён мөсөн ноёнтныг барьц алдуулж орхилоо. "Тлэлгүй яахан, би зөвшөөрлөө. Тэр зэргийн ажлыг хийхгүй дээ Амлалтаа биелүүлж чаддаг улс гэж таныг ч найдаж байна. Адал явдал, аюул ослоор дүүрэн амьдрал надад сонирхолтой" 1-нд л оодоос нь дуржигнуулж гарчээ. Дараа нь, шуурхай хүрс гэж болох 5 удаагийн уулзалт Гриний гэрт болжээ. Тагнуулын захидал бичих, ТТГ-ын цахилгааныг радио холбоогоор барих, нууц бичгийг шифрээр тайлах, бичил цэгийг мэдээллийг дамжуулах, далд газруудыг ашиглах зэрэг эрдэм авьяаслаг залууд хялбархан санагдав. Томилот дуусч, Волгин Москвадаа буцлаа. 7 хоногт 2 удаа 22 цагт Майны Франкфүртээс хандах учиртай Гриний өгсөн сони транзистороос час час гэсэн содон дохио дуулдсанаа *эмэтэй* хүний хоолой "зибен... гэхэд Семён хичнээн догдолсон гээ. Үлгэрт гардаггүй явдал. Бас хурц тод ирээдүй. Тоонуудыг шифрээр тайлан үг болгож уншина. "Палихын гудамжны 26-д трамвайны аьтомат сумны төмөр хайрцаг байдаг. Тэнд ургасан бутан дунд сүхний иш буй. 21 цагт очиж аваарай. Дотор нь даалгавар, шинэ шифр, микрофиш харах төхөөрөмж, тусгай цаас, 3000 доллар хийсэн" хэмээсэн байжээ. Даалгавар нь хэцүү байсангүй. Гадаад яаманд бол хэнд ч сонин бус энгийн зүйлс америкчуудад үнэт мэдээлэл болж хувирдаг нь хачирхалтай. Семён гайхалтай хамт олонч, найрсаг зант нэгэн санагдах тул хүн бүр л түүнтэй нөхөрлөхийг хүснэ. Өөрөө бараг амсахгүй хэдий ч балгах дуртайчуудыг ихэд ойлгож, мөнгө зээлүүлнэ. Сонорт нь яамны нандин "нууцууд" цуглана, сониуч занг нь өхөөрдсөн нөхөд чухал баримтуудыг үзүүлнэ. Манай хүн бөгжинд нь буй бичил аппаратаар зураг авна, нууц газраас авсан заавартай цаасыг стакан усанд хийж юу ч үгүй уусгана, гадаад руу явуулах захидлыг цэгүүдийн оронд микрофиш наана, ойд мөөг түүхдээ 10 мянган доллар олно. Энэ маягаар 3 жил ажиллажээ. АНУ-ын ТТГ-ын дэслэгч цолыг хүртжээ. Зуслангийн байрны шалан дор 250 мянган доллар нуусан байв. Хүмүүс тагнуулчид зөвхөн телевизийн дэлгэцнээ оршдог мэт санаж, амарлингуй царайлан байхад ингэж суперлэж буйдаа Семён маш сэтгэл ханамжтай. Над шиг ухаантай, чадвартай нь хэзээ ч баригдахгүй гэж бодно. Гэхдээ Зөвлөлтийн нөхцөлд ийм их мөнгөөр юу хийх билээ. Ядаж Москвич авчихлаа гэхэд мөрдөж мөшгөөд унана. Илэрч магадгүй байна, намайг Америк руу гаргаач гэж баашилсан захидал бичив. Цаанаас саналыг нь дороо хүлээж зөвшөөрөхөд Семён алмайрлаа. Явах бэлтгэлээ хийж эхлэв. АНУ-ын ЭСЯ-нд очиход л хангалттай, тэнд бид чамайг хүлээж авна, улс төрийн орогногч маягаар гаргана гэж түүнд мэдэгдсэн байлаа. Нэг мэдээнд түүний авьяас чадлыг баахан магтаад, харин чамайг КГБ-гийн хараанд өртсөнөө биднээс түрүүлж мэднэ гэж арай санаагүй гэсэн аж. Үүнийг уншаад мань хүний

бүр хар хөлс чийхрав. Элчинд очих өдөр нь болоогүй л байлаа. Америкт амьдарна, диваажингийн жаргалд умбана гэх бодол л түүнийг тайтгаруулна. 250 мянга гэдэг тэнд ч их мөнгө. Бас дээрээс нь ТТГ ивээн тэтгэнэ...

Гэвч түүнийг эл хөлдүү газар явж байхад нь хэсэг хүн дайрч, ам хамрыг нь алчуураар таглажээ. Нэг ухаан ороход тас харанхуй, хүйтэн камерт хэвтэж байв. Бүх юм дууслаа. Түүнийг тамлан Намцааж, хамаг нууцыг хэлүүлжээ. Эх орноосоо урвасан гэж цаазаар авчээ. Ийм бизнес хийгчид Зөвлөлтөд цөөнгүй байлаа. КГБ-гийн хурандаа, английн МИ6, америкийн ТТГ-ын агент Олег Неньковский тагнаж эхлэхдээ 3000 рубль, 1000 паунд авчээ. Сар бүр 1500 доллар, 1000 паундийн урамшилтай байлаа. Мөн мэдээлэл нь тусгай гонорартай. Арми, цэргийн техник, улс төр, КГБ-гийн кадрын аппаратын талаар мэдээлж байв. 1963 онд баригдаж, дээд хэмжээ СОНСЧЭЭ. Дмитрий Поляков, КГБ-гийн генерал, ТТГ-ын агент. Военная Мысль нууц сэтгүүлийн 100 дугаар, зэвсэглэл, Вьетнамын Камрань дахь зөвлөлтийн цэргийн баазын тухай мэдээлэл зэргийг дамжуулж, Английн БХЯ-дбуй зөвлөлтийн тагнуулын нэрийг өгч, 100 гаруй мянган доллар авчээ. 1986 онд илэрч буудуулсан. Геннадий Сметанин, КГБ-гийн офицер. ТТГ-аас 1 сая доллар хүсч, дараа нь 360 мянган доллар дээр тохирч, материал худалдсан. Тэр нь КГБ-ийн операциуд, агентуудын тухай байлаа. 1985 онд цаазаар авахуулсан. Адольф Толкачев цэргийн МИГ үйлдвэрийн инженер. МИГ онгоцны удирдлагын электрон тогтолцоо, зөвлөлтийн Стелс системийн техникийн баримт бичгүүдийг 800 мянган рублиэр худалдсан. 1986 онд цаазлагдсан. Александр Огородник, ГХЯ-ны ажилтан. ТТГ-ын Тригон Несвдонимотой агент. Олон зуун нууц дипломат цахилгааныг дамжуулсан. 200 гаруй мянган доллар авсан. 1977 онд баривчлахдаа шатнаас үсэрч амиа хорлосон. Сергей Фёдоренко, жолоодлогот пуужингийн мэргэжилтэн. Өөрийн салбарын нууцыг америкчуудад өгч байсан, 600 мянган доллараар шагнуулсан. 1990 онд америк руу зугтаж чадсан. ТТГ хамгааладаа авч, нэмж 330 мянган долларын чек өгсөн. Олег Гордиевский, КГБ-гийн офицер, британий агент. КГБ-ийн тагнуулын операци, гадаад агентүрийг илчилж байв. Зөвлөлтөөс 1985 онд гарч чадсан, нийч 350 мянган паунд хулдаасалж байсан. Өдгөө МИ6-ийн ивгээлд буй. Владимир Резун, КГБ-ийн ахмад, английн агент. КГБ-гийн Европ дахь үйл ажиллагааг америкчуудад танилцуулж байна, бараг 1 сая паунд авсан. 1978 онд Британи руу оргож, МИ6-гийн хамгаалалд орсои. Виктор Сүворов нэрээр зөвлөлт дэглэмийн үнэн нүүр царайг харуулсан номууд бичмж, дэлхий даяар алдаршсан, цаазын эчнээ ял нь хүчинтэй байгаа. Тэдэнтэй зэрэгцээд америкчууд ч ийм хачирхалтай бизнесийг оросуудаас дутахгүй хийж байв. 1968 онд Зөвлөлтийн ЭСЯ-нд ахлах офицер Жон Энтони Уокер таксигаар иржээ. Тэр шифрийн машинд зориулсан тухайн сарын нууц түлхүүрийг үзүүлж 20 мянган доллар авчээ. Түүний ачаар КГБ америкийн армийн Вьетнамд явуулах тэнгисийн болон агаарын операцийн тухай урьдчилан мэдэж байн. Уокерт зөвлөлтийн флотын хурандаа цол шагнажээ. Гэвч эхнэр нь ТТГ-д ховлосноор мань хүн хурандаа цолоо 127 жил хоригдох ялаар солин. Хадгаламжинд нь 425 мянган доллар байжээ. 1973 онд Баруун Берлин дэх британий АЦХ-ний электрон тагнуулын баазын ажилтан Жеффри Прайм салбарынхаа мэдээллийг худалдахаар шийджээ. 1982 он хүртэл ажиллахдаа 1,1 сая гаруй дойчмарк авчээ. Англи руу шилжүүлэгдсэнийхээ дараа танхайн хэрэгт холбогдож, улмаар насан турш танхайрах боломжтой болов. ТТГ-ын офицер Олдрич Эймс 1985-1994 онд КГБ-гээс 2,7 сая доллар авсныг ХМТ тогтоожээ. Колумби дагина Мария дель Розарио Касас өөртөө татахын тулд эрсдэлтэй алхам руу хэлбийжээ. Вашингтон дахь КГБ-гийн төлөөлөгчид 50 мянгыг өгвөл ЗХУ дахь ТТГ-ын 3 агентын

нэрийг хэлж өгнө гэсэн зурвас илгээв. Чанга гэгч боосон зуутын дэвсгэртүүдийг заасан газар нь орхисныг үзээд Эймс бүр хашгирч орхижээ. Гэвч түүнийг нь 9 жилийн л дараа сонссон юм. Тэр 325 жил хоригдох болжээ.

БИЛЛ ГЕЙТС

Программ хангамжийн бөмбөгдөгч

Билл Гейтс 1993 онд жилд тэрбум давсан орлоготой ажиллах чадвартай болж, Форчүн түүнийг Америкийн гэргүүн баян гэж зарласан билээ. Амжилтад хүрэхдээ баримталсан зарчим нь "Удирдагч байх гэхээсээ илүү бусдыг зөв дагаж чаддаг хүн мэргэн ухааныг олж чадна" гэж хэлсэнд нь оршино.

Техниктехнологийн дэвшил нь шинэчлэгчүүдийн цуцашгүй Хөдөлмөрийн дүнд бий болсон бөгөөд Гейтс тэдний бүхий тэргүүний санааг нэгтгэн гарамгай бүтээлээ буй болгодог. Үүнд түүний хурц ухаан, эвлэг чадвар их нөлөөлсөн. Тэр удирдагчийнхаа хувьд хатуу чанд бодлого явуулдаггүй агаад, зөвхөн техникийн оновчтой шийдэлд чамбай хандахыг ажилтнуудаасаа хүсдэг. Гейтс Харвардын математикийн факультетэд байхдаа компьютерийн асуудлыг яггүй сонирхож, үүнийг л хамаг ирээдүй минь гэж үзжээ. Программ хангамжийн бизнес эрхлэхээр шийдэж, 1975 онд Майкрософт компани байгуулав. Улс орон даяар аялан явж, хамтран ажиллах залуу авьяастнуудыг хайжээ. Алтан овоо, туршхи ажил бүтээлийн бүрэн эрх чөлөөг амласанд нь тэр бүхий татагдаад байсангүй. Гэхдээ урт удаан аялал нь түүний нүдийг нээж, маш ихийг ойлгуулав. Мөн Вашингтоны их сургуулийн оюутан Пол Алленыг олсон нь азтай хэрэг байлаа. Гейт Аллен хоёр сайн найзууд, компанийг хамтран эзэмшигч болов. Сод чадвартан Аллен байгаагүй бол Гейтсийн тавилан хааш эргэх байсныг бүү мэд. Аллен тэр хоёр өдөр шөнөгүй гүрийсээр бейсик хэлний сайжруулсан хувилбарыг гаргаж ирэв. Биллийн ээж бүтээгдэхүүнийг борлуулна гэдэг байсан бөгөөд ИБМ, АТ энд Ти -гийн удирдлагаас ч сүрдэлгүй давхиж ороод ухуулж гардаг байлаа. Персональ компьютерийн өргөн үйлдвэрлэлд орохоор шийдсэн ИБМ үйлдлийн системийн (ҮС) шалгаруулалтдаа хэний ч мэдэхгүй микро компани Майкрософтыг урьсан нь ээжийн сурталчилгааны ач гэлтэй. Шинэ санааг ажиглан судалж нэгтгэн тоймлож чаддаг Гейтс Сиэтл компьютер Продактс компани ДОС гээч ҮС бүтээгээд амжилт олоогүйг ашиглахаар шийдэв. Түүнийг худалдан авч, боловсронгуй болгосон нь ИБМ-д таалагджээ. Зальт Билл ИБМ -тэй үлэмж хожоотой гэрээ байгуулав. ҮС бүтээхэд гарсан бүх зардлыг ИБМ төлнө, үйлдвэрлэсэн РС дээ зөвхөн ДОС-ыг дагуулна, борлосон компьютер бүрээс 1 Майкрософт хувь авна, ДОС-ыг худалдахад Майкрософт бүрэн эрх чөлөөт эдлэх ба үүнээс ИБМ нэг ч цент авахгүй гэсэн зүйлүүдийг зөвшөөрүүлж чаджээ. Хожим ИБМ гэрээг өөрчлөхийг хүссэн ч, богино хугацаанд хүчирхэгжсэн Майкрософт тийм боломж олгосонгүй үй. 1981 онд бүх хөгжингүй орон РС үйлдвэрлэх болж, гэхдээ цаг хожихын тулд шинэ ҮС зохиолгүй, шууд ДОС-ыг сонгож байв. Компек, Делл, Хьюлетт Паккард гээд том фирмүүд ч мөн адил. дэлхийн компьютерийн 80 хувьд ДОС суугдаж, Гейтс тэрбумтан, монополист боллоо. Хөөрхий Пол Аллен хэт ачаалалтай ажилласнаас сулран доройтож, Билл түүнд 4 тэрбумыг өгөөд эрх, акциас нь татгалзуулснаар компаниа ганцаар эзэмшив. Аллений авьяасыг шинэ мэргэжилтнүүд орлолоо. Гэвч Эпел, Некст зэрэг писи өөр ҮС-ээр ажиллаж байв. ДОС ч хоцрогдож эхэллээ. Гэтэл Майкрософт Үиндоүз 3.1-ийг I аргаж ирлээ, өрсөлдөгчиддөө хямд бэлэг барив. Үиндоүз бол мянга мянган ажилтны 10 жилийн хөдөлмөрийн үр дүн. Тиймдээ ч Гейтсийг программ хангамжийн хаан

болгож чадлаа.1990 оны эхээр электрон шуудан болом олон улсын компьютерийн нэгдсэн сүлжээ хөгжиж эхэллээ. Хөгжил дэвшлийн манлайд явах нь л чухал гэдэг Гейтс сүлжээ рүү дайрав. Интернет үзэх программ болох Браузерийг хэн сайн бүтээх вэ гэсэн зарлаагүй уралдаан өрнөлөө. Гэтэл Майкрософтоос өмнө Нетскэйн комьюникэйшн 3 компани Навигатор хэмээх давгүй браузер бүтээчихлээ.Гейтс сайжралд орлоо. Спайглэн компаний программыг хуулбарлахад хүрлээ. Нэмж шинэ үйлдлүүд, вирүсийн эсрэг программ, ялгагдах бусад зүйлүүдийг суурилуулан, өөрийн болгож авлаа. Ийнхүү Иитернет Эксплорер 1.0 мэндэллээ.Гэвч энэ программ шууд гүйлгээгээр бол компанид нэг ч долларын ашиг авчраагүй юм. Учир нь Майкрософт өрсөлдөгчдийг өндийлгөхгүй гэсэндээ браузерээ Үиндоуз дагуулан үнэгүй түгээж байлаа. Хэрэглэгчид бусад компаниас браузер авах ямар ч шаардлагагүй болов. Тэртэй тэргүй монополь ҮС Үиндоүзтэй хамт хүрээд ирж байгаа хойно. Ингэснээр хүмүүст зөвхөн Майкрософтын бүтээгдэхүүнийг авах хэрэгтэй гэсэн бодлыг төрүүлэв. Аажимдаа хүмүүс Майкрософтоос өөр программын компани байдгийг ч мартаж дөхөв.АНУ-ын Шүүх Яам шинэ монополь төрсөнд түгшиж, Гейтсийг Спайглэний бүтээлийг хуулбарласан гэж хэрэгт татлаа. Гэвч амжилт олсонгүй. Ажлын өвөрмөц арга барилаа цаашид ч Гейтс орхиогүй юм.Удалгүй бас нэг монополист алхам хийв. Худалдаанд гаргасан MS Офис хэмээх багц программ нь бичиг хэргийн бүх шаардлагыг хангаж байлаа. Түүнд нь эх бэлдэх Үорд, хүснэгтийн Эксел, элдэв танилцуулга, чимэг хийх Паүэр Поинт, вэб сайтын Фронт Пэйж, өгөгдлийн сангийн Аксисс, и мэйл бичих, ажлын хуваарь зохиох Аүтлүк гээд л байхгүй юм байхгүй.Гейтс Энэтхэгээс нэлээд компютерчийг цагаачлуулснаар боловсон хүчний асуудлаа сонирхолтой шийдсэн. Энэтхэг улсын нэгэн засгийн газар гэв гэнэт электроникийн тэргүүний гүрэн болно хэмээгээд уг салбарт асар их хөрөнгө оруулсан билээ. Дараагийн засгийн газрууд ч хичээсээр буй Үр дүнд нь компьютерийн хотхон сүндэрлэж, олон мянган нарийн мэргэжилтэн бэлтгэгдсэн. Тэдгээрийн гайгүйчүүдээс Гейтс хуу хамсан.1995 оноос эхлэн Америкийн шүүх Майкрософтруу довтолж гарсан. Эксплорер браузерийг Үиндоүзэд хавсарган дагуулж, үнэгүй өгч байгаа нь бусад компанид браузер бүтээх, худалдах боломжийг олгохгүй байна, монопольчлох үйлдэл болж байна гэж шүүх буруутгалаа. Эксплорер, Үиндоуз хоёрыг салгаж, тус тусад нь зарах хэрэгтэй гэж тулгав. Гэвч Гейтс өөрийнхөөрөө зүтгэсээр буй.Компьютертэй болгон Майкрософтын бүтээгдэхүүнийг хэрэглэхэдглэхэд хүрдэг. Үиндоуз, Эксплорер, Офис зэрэг монополь ирограммынхаа ачаар Гейтс дэлхийн том баян болсон. Өдгөө тэр бүтээгдэхүүнийг нь зүй бусаар хувилан ашиглаж буйн эсрэг тэмцэлд ихээхэн хүчин чармайлтаа зориулж байна. Майкрософтын гол ирограммууд 300-1000 гаруй долларын үнэтэй. Гэтэл хөгжингүй орнуудаас бусдад уг программуудыг үнэгүй л олшруулж ашиглаж байгаа. Жишээ нь, Хятадад Майкрософтын программыг худалдан авсан хүн нэг ч байдаггүй аж. Хэрэв ийм асуудал үгүйсэн бол Гейтс одоогийнхоосоо 10 дахин баян байж болох асан. Тиймээс Майкрософт программаа хувилж олшруулах боломжгүй болгохоор шамдан ажиллаж байна.

Хүүхдийн тоглоомын асар ирээдүйтэй зах зээл рүү орж, Эйж оф Эмиаер, Эйж оф Мифоложи, Данжн сиж, Райз оф зэрэг супер тоглоомууд бүтээсэн. Тэдгээр нь 8 настай балчраас, 80 настай буурлыг хүртэл байлдан дагуулсан тоглоом болжээ.

Мөн хардвэйрийн өргөн салбарлуу довтолж, компьютерийн элдэв тоноглолыг хийж эхэлсэн. Үиндоуз программ жил ирэх тусам төгөлдөржиж, Профэшнил,

Миллениум Эдишн, Экс Пи зэрэг хүчтэй салбаруудаа гаргасан бөгөөд, 2004 онд өргөн барихаар зэхэж байна. Бусад чухал программ нь ч байнга шинэчлэгдсээр. Адоб Макромедия, Ай Би Эм, Эйпл зэрэг өрсөлдөгчид нь мөрөө хавчихаас өөр аргагүйд хүрэх аж. Гейтсийн цорын ганц сонирхдог зүйл нь компьютер юм. Гэртээ хариад компьютерийн ертөнцдөө л умбана. Тэрбээр кибер байшин гээчийг бариулсан бөгөөд түүний эд эс бүхэн нь цахим тооцоолуурт захирагдана. Хаалга нь Гейтсийг ирэхэд өөрөө онгойно, өрөөнүүд хүн ороход л гэрэлтэнэ, дэлгэцэн хануудад ямар ч дүрслэлийг гаргаж болно, агаарын чийгшил, дулаан, хүчилтөрөгчийн хэмжээ, цэвэр байдал автоматаар зохицуулагдана, ямар нэг юм болохгүй болбол компьютер өөрөө ийш тийш утасдана, спорт танхимдаа ороход нь хөгжим хангинана, ор нь бүүвэйлнэ. Зөвхөн компьютер сонирхдог нь түүнийг гаж буруу араншинтай болгосонд гайхах явдалгүй. Тэр 37 насандаа программч бүсгүй Мелинда Фремчтэй гэрэлсэн хэдий ч ганц бие юм шиг л байдаг. Гэргийдээ өөрт нь хоол бэлтгэхгүй байхыг тушаасан агаад, гадуур хооллох буюу бэлэн зоог сугавчлан орж ирнэ. Хүүхдүүдийгээ бүтэн нэрээр дуудаж, ажилтандаа хандах мэт харьцна. Амралтын өдрийг мэдэхгүй тэр хоногт доод тал эь 10 цаг уйгагүй хөдөлмөрлөнө. Ажлын газрынханруугаа гэр лүү нь байнга утасдаж, и мэйл явуулдаг. Гэрэлхээсээ мөн бараг харьдаггүй, офистоо хонодог байсан. Олон хоног дараалан гурав дөрөвхөн цагийг л нойрондоо зориулж, заримдаа 7 цаг унтсанаар эрч хүчээ нөхчихлөө гэдэг. Их төлөв нэг зэрэг хоёр юм хийж байдаг. Юм уншихгүйгээр идэж ууж чаддаггүй бөгөөд биеийн тамир хийхдээ ТВ үзэж, компьютер дээр ажиллахдаа утсаар ярьж, машин барихдаа зогсоо зайгүй сүү ууна. Түүний машины хойд суудал сүүний хайрцгаар дүүрч, үнэр танартай болсон байдаг ажээ. Бас айхавтар яхир зантай. Цэцэрлэгтээ том мод тариулсны дараа, миний яг заасан газар биш байна гээд гухчхан см-ийн зайд ахин суулгуулж байжээ. Яхир зангаас нь болж хэн ч дутагдлынх нь талаар хэлж эс зүрхэлнэ. Мөн найз нөхөдгүй. Түүний удирдлагын систем гайхалтай. Ажиллагсдын бүх компьютерийг нэг сүлжээнд холбосон. Тэр хэн юу хийж буйг тодорхой харж байх боломжтой. Ажилтнуудын дэлгэцнээ түүний гэгээн дүр гэнэт мэлсхийн гарч ирж загнадаг. Тэдэнтэй зөвхөн сүлжээгээр л харьцна. Жилд тэрбумыг олдог Гейтс иймэрхүү л хүн юм.

ЖАН ПОЛЬ ГЕТТИ

Ганцаардлал чоно

Ирланд гаралтай үй олон үгээгүй тариачид Америкт ирж, эрч хүч, хичээл зүтгэлээрээ энэ орны хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулсан бөгөөд тэдний дотор Геттийн гэр бүл байсан юм. Эднийхэн газаргүйн улмаас уугуул Ирланддаа ахиж дэвшиж чадахгүй байв. Харин Америкт ирээд, амжилт олох хүслэнгээр жигүүрлэцгээжээ. Хамгийн анхны бизнес хийсэн Гетти Миннеаполисд " өмгөөлөгч байснаа олны чиг хандлагаас хоцордог 'й зангаараа нефтийн наймаандоролцов. Тэр энэ ажлыг улайран сонирхож, ашиг орлогоо нэмэгдүүлэхийн төлөө юунаас ч буцдаггүй байлаа. Ирландынхаа мафиудтай ч нягт хамтран ажиллаж байв. Үүнээс болж, хэл ам, хэрэг төвөгт олонтаа холбогдсон ч өөрийгөө дээд зэргээр өмгөөлж чаддаг тэр уснаас хуурай гарч чаддаг байлаа. Хүү Жан Поль нь эцгийгээ хар багаас бишрэн шүтэж, алхам бүрийг нь дууриан өсчээ. Сурагч байхдаа л тэр сурлага сайтнуудыг юхион байгуулж, тэднээс бүх төрлийн даалгаврын гүйцэтгэлийг худалдан авдаг гэрээтэй байсан агаад түүнийгээ сод бус ухаантнуудад хуулуулж, зардлаасаа арав дахин давсан ашиг олно. Илчлэгдсэн гүүнийг багш нар ихэд зэмлэн

донгодож, харин эцэг нь магтан сайшааж, өөрийнхөө бизнесийн хэргийг тайлбарлан ярьж өгдөг болов.

Тэрбээр биеэ өмгөөлж чадах нь бизнест маш чухал хэмээгээд, хүүгээ Английн хамгийн сайн дээд сургуульд өмгөөлөгч Сьюлгохоор илгээлээ. Жан Поль сургуулиа муугүй төгсгөсөн хэдий ч хууль зүй бус, бизнесийг судлахад хамаг цагаа зориулж байжээ. Англиас тэр Оклахомын нефтийн орд руу довтолох нь нэн ашигтай гэсэн бизнесийн бэлэн төлөвлөгөөгөөтэй ирэв. Түүнийгээ аавдаа ктилцуулахсан гэж олон хоногоор хүсэн мөрөөдөж байсан нь дампууран уналаа. Эцэг нь хүнд өвчин тусч, хэвтэрт орсон байв. Бизнесийн тухай огт үл сонирхож, гагцхүү өнчин хүүхдүүдийн тухай л ярина. Иймэрхүү яриаг эх нь л гаргадагсан. Тэрбээр нэлээн шүтлэгтэй эмэгтэй байсан агаад, янз бүрийн буяны үйлсэд мөнгө хандивлуулахаар ямагт нөхрийгөө ятгаж иржээ. Энэ удаа ч өвгөн саятанд яаж ийнхүү гүн гүнзгий нөлөөлж чадсаныг бүү мэд, юутай ч гэсэн тэр зөвхөн хүүхдийн фонд байгуулах тухай л үглэнэ. Жан Поль эцгийгээ элий балай болж хэмээн дүгнээд, эрүүл ухаан орох йайгаа гэж найдна. Гэвч байдал өрчлөгдсөнгүй. Өвгөн бүх хөрөнгөөр олчин хүүхдийг асрах фонд байгуулна хэмээн гэрээслээд өөд болжээ. Харин хүүдээ "Чи мөнгийг зөвхөн хөдөлмөрлөж байж олох учиртай. Үүнийг л сайн санаж яв" гэж хэлсэн нь өв болж хоцров.

Жан Поль энэ хачин явдалд ихэд гутран, орь дуу тавин уйлмаар байсан ч Оклахомын үйлсээ бодон өөрийгөө тайвшруулна. Зээл олгохыг эхээсээ гуйсан ч эс зөвшөөрөв. Гэрээслэлд заасныг юрчвөл хууль бус явдал, нүгэл хилэнц болно гээд огт хөдөлсөнгүй. Жан Полийн хор шар хөдөлж, гэрээсээ бүрмөсөн явжээ. Ямар ч эмчгүй тэрбээр гарааны мөнгө олох гэж их л зүдэрсэн юмдаг. Найз нөхдөөс мөнгө цуглуулж, янз бүрийн буяны байгууллага, тусламжийн төслүүдийг гүйцээв. Санаж явбал бүтнэ гэгчээр нэгэн провч баян Оклахомын олборлолыг нь ивээн тэтгэхээр амлажээ. 2 жил галзуурсан мэт уйгагүй хөдөлмөрлөөд, анхныхаа сая долларыг олжээ. Эхэндээ геологийн өрөмдлөг, дэлбэлэлтэд хүртэл гар бие оролцож, ажилчидтайгаа мөр зэрэгцэн зүтгэдэг байв. Нефтийн ордоосоо өдөр ч, шөнө ч үл холдон, 100 долларын үнэтэй ямбийн форд машиндаа унтдагбайлаа. Түүний ингэж ажиллаж байсан нь Америкийн эдийн засгийн агуу хямралтын үед тохиожээ. Энэ нь асар их бэрхшээлийг учруулж байсныг ч хэлэх үү. Эцэг эхдээ хязгааргүй гомдовч, харин ч хэн болохыгөө үзүүлж өгөх хүсэл нь улам оволзоно.

Олсон ашиг орлогоо зовхой акци худалдан авахад зориулдаг байлаа. Хоосрохоос эмээсэн хүмүүс акцидаа Геттид хямд гэгч худалдахдаа хямралын үед үүгээр яах осэн юм бол оо гаж гайхна. Үнэндээ гайхахаас ч өөр аргагүй. Бүх мөнгөө хуньцаанд зарцуулдаг тэрбээр уранхай хуицастай, өлөн ходоодтой яиах тул хачирхам харагдана. Тохой цоорхой атлаа хамаг зоосоо удалгүй үнэ цэнэгүй болох акцид зориулж байна гэдэг дэндүү гайхалтай. Харин Жан Поль тэднээс илүү алсын хараатай. Америк орон бэрхшээлтэй учирсан ч түүнийг даван туулах гэж тэмцэж байв. Эдийн засгийн амьдрал үргэлжилсээр л, шинэ эрч хүчийг олсоор л. Тиймээс Америкт нефть ч хэрэгтэй, хөрөнгө оруулалт ч хэрэгтэй, авсныгаа өгөх потенциалтай ч байлаа. Их хямралын үед сандарч тэвдэлгүй, ухаалаг зоримог алхмуудаа хийсээр Гетти хүч чадал ихт үлэмж биетэнг санагдуулам болов. Нефтийн том компани Тайдуотерын акциг хянахын төлөө анхныхаа том тулаанд орлоо. Өнчин хүү хочтой болж, өрөвч баячуудаас мөнгө цуглуулж явсан залуу ингэж өсч дэвжих гэж. Бизнес санхүүгийнхэн бүгд л шагшран гайхавч амжилтад нь үл итгэнэ. Тэдний үл итгэх нь Геттид хамаагүй аж. Гол ньөөрөө л итгэж байвал барав. Тайдуотерийн мэдэлд газрын тосны баялаг ордууд, нефть нэрэх олон үйлдвэр, бензин түгээх

газруудын нүсэр сүлжээ багтана. Даанч эзэн нь алдаатай бодлого явуулснаас болж, акциудаа зарж, амь хоохойлоход хүрсэн юмсанжээ. Геттийн өмнө Рокфеллерийн Стандарт ойл хөндөлсөв. Ер бусын авхаалж самбаа, тактик, шаргуу чанаруудаа дайчлан байж Жан Поль Стандардаас дутахгүй тооны акци олж авахыг эрмэлзэнэ. Ноён Тайдуотерт ятгахдаа, зөвхөн Стандардад акция зарж яавч болохгүй, Рокфеллерийн эрхшээлд орвол юу ч үгүй хоцроно шүү гэж итгүүлж дөнгөв. Мөн санхүүгийн мэдээ, статистикийг уйгагүй судалсны эцэст Рокфеллерийн гэр бүлийн нэг гишүүн алдаа хийж болохыг ойлгожээ. Шууд л дайралтаа хийж, түүнээс Спартан компаний хянах эрхийг салгаж чадлаа. Спартан нь онгоцны эд анги "члдвэрлэдэг агаад, Тайдуотерийн даруухан нэг салбар юм. Рокфеллрүүд агаарын салбарыг үнэлэх тал дээр хоцрогдмол байсан тул Гетти уг үйлдвэрийг сонгожээ. Удалгүй дэлхийн II дайны утаа айсуу болоход Спартан Америкийн армиас асар их захиалга авч, нэн хүчирхэгжив. Геттийн авьяас чадварыг үнэлсэн Роял Датч Шелл стандартын эсрэг тэмцэлд түүнийг дэмжих сонирхолтойгоо илэрхийллээ. Гетти ч дэмжлэгийг нэн ашигтай гэрээ болгон хувиргаж чадав. Үүнд, Шелл Тайдуотерийн акциын нэлээд хэсгийг авч, гуравдагч том эзэмшигч болох агаад, 10 жилийн дараатүүнийгээ Геттид худалдах учиртай. 16 жил тэмцэлдсэний эцэст, Гетти Рокфеллерийг ялсан цөөн хүний нэг нь, Ганцаардмал чоно хочтой Гетти гэгдэв. Жан Поль энэ хугацаанд зөвхөн Тайдуотерийн төлөө тэмцэж байсангүй, 20 орчим салбарт бизнес үйл ажиллагаа явуулж, мангас болтлоо өссөн юм. Гэхдээ л 1950 онд дууссан түүний 16 жилийн тэмцэл л Геттийг жинхэнэ мангас болгосон билээ. Дэлхийн дайны дараа Гетти хачирхалтай довтолгоо хийсэн юм. Саудын Араб, Кувейт, Иракийн дунд улс төрийн маргааны дүнд үүссэн Дундын бүс гэж байв. Бахрейн улсаас 10 дахин их нутагтай дундадын бүс ямар ч улсад үл харьяалагдана, тэнд хэн ч үл сууна. Бүсэд нефть олборлох бодол хэний ч санаанд орсонгүй. Харин Геттийн тлгойдтөржээ. Тийм эрх мэдэлгүй Саудын хаанаас 13 саядоллараар мсфть олборлох концесс худалдаж авав. Үнэндээ энэ нь Саудын мутгаар дэмжин өнгөрч байх төлбөр байлаа. Үүнд бусад улсууд дургүйцсэн ч, яаж ч чадсангүй. Дундын бүсэд хамгийн тааламжтай ажлын нөхцөл байв. Энд олборлосон хэмжээгээ хэнд ч тайлагнах албагүй, эндхийн засгийн газарт татвар төлнө ч гэж байхгүй. Ямар ч бизнесийн өрсөлдөгч үгүй, улс төрийн дарамт шахалт, олон нийтийн санаа бодол, үйлдвэрчний эвлэл ч үгүй. Тэр ч бүү хэл, хууль үгүй. Дундын бүс Геттийн хэмжээгүй эрхт хаант улс байлаа. Дундын бүс Геттийн мөрөөдөл байлаа. Энд дэлхийн нефтийн 2 хувийг олборлож байсан нь нэг чүмий хувьд юутай их мөнгө билээ. Түүнээс хойш Гетти "Эзэнт улсаа" эцэж цуцалтгүй пргожүүлсээр л байлаа. Өөрөө английн нэг цайзад амьдардаг байв. Өвдөхөөс ихэд айх тул зөвхөн жимс ногоо идэж, амандаа хийснээ ианал 33 зажилж, 7 хоногт нэгэнтээ мацагбарьж, иогоор хичээллэж, и морлэгээ арчилдаг гэнэ. Мөн эцгийгээ нас барснаас хойш, ээж иопон хамаатнуудтайгаа хэзээ ч эргэж уулзаагүй, ганц ч үг гараагүй ажээ.

ДАНИЭЛЬ ГЮДЕВЕР

Хэл шинжээч мэргэжлээ сольсон нь

Даниэль Гюдевер хэл шинжээч болохыг мөрөөддөг байлаа. Сорбонны их сургуулийн филологийн факультетийг онц үзүүлэлттэйгээр төгсгөжээ. Их сургуульд уран зохиолын багшаар үлджээ. Гэвч түүний судалгаа нэг л үр дүн муутай байлаа. Бараг 7 жилийн турш нотлохыг ородсон таамаглал нь явуургүй байсан аж. Уг нь зөв зүйтэй таамаглал байсан бол хэл шинжлэлд сенсаци тарих байлаа. Амар хялбар сэдэв сонгож, богино хугацаанд цол хамгаалсан нөхөд нь түүнийг Бүтэлгүйхэн гэж нэрлэнэ. Түүний урагшгүй амьдралыг хобби нь л

чимэглэнэ. Даниэль багаасаа автомашин сонирхдог байлаа. Сурагч байхдаа л авто инженерийн дайтай мэдлэг хуримтлуулсан. Чөлөөт цагаа засварын газар өнгөрүүлж, алтан гартай хэмээгдэнэ. Нэрд гарсан шинэ загваруудыг хичээнгүйлэн судлаа. Их сургууль түүнийг хоббигоос нь огтхон ч хөндийрүүлээгүй. Бензин тос үнэртүүлсэн л! багшийг цэмцгэр доктор профессорууд хялайж, олон хэлээр зэмлэнэ. Баян оюутнууд үнэтэй ганган машинаа мань хүнд түр хэрэглүүлж, шалгалт шүүлгээ аргална. Хүндэт гишүүн тэр авто клубдээ л бүрэн ойлголцлыг мэдэрдэг байв. Төмрийн сэг зэмээс босгосон Феррарийн ховор загвараараа Гюдевер ихэд бахархана.

Уг нь, автомашины үг хэллэгийн судалгаа хийсэн бол яг таарах байж. Гэвч 30 гарсан эрхэм багш эрдмийн карьерт ч ахихгүй, гэр бүлгүй бөгөөд, хөлсний байранд амьдарсан хэвээр байв. Ирээдүйгүй гэгдэн их сургуулиасаа халагдсан нь эргэлт боллоо. Авто клубийн анд нь түүнийг хөнгөн тэргийн дэлгүүрт ажиллууллаа. Манай хүн нэгдүгээрт авто ертөнцийг тавьж, хэл шинжлэлийг хобби болгох учиртай байсныгаа сая л ухаарав. Амьдралд нь гарсан энэ өөрчлөлт Даниэлийг шинээр мэндэлсэн мэт л болголоо.

Европын 7 хэлийг гаргууд эзэмшсэн, техникийн өргөн мэдлэгтэй авьяаслаг худалдагч Ситроений түшмэдийн анхаарлыг татав. Ийнхүү экс хэл судлаач Францын автогигантын борлуулалтын албанд ажиллах боллоо. Менежментийн ухаанд бие даан суралцаж эхлэв. Түүний өмнө жинхэнэ амьдралын их сургууль нээгдэв. Ситроений үйлдвэрлэл хоцрогдсон байснаас болж ашиг орлого тун муутайхан байсан юм. Гэвч Гюдевер борлуулж дөнгөж л байлаа. Удирдлага түүнийг хүнд байдалд орсон Швейцарийн салбартаа илгээв. Тэндхийн ажлыг ч сайжруулж дөнгөлөө. Харин Германы салбар луу шилжүүлсэн нь залуу борлуулагчийн хувьд хатуу сорилт байлаа. Ситроен герман машинуудын хаана нь ч хүрэхгүй тул нэг нь ч эс зарагдана.

Илүү тааламжтай нөхцөл амласан Ренод ажиллах болов. Гэвч Францын автомашины үйлдвэрлэл хуучинсаг, хүнд сурталтай нь Даниэльд таалагдсангүй. Авго ертөнцөд ажилласан шиг ажиллая гэвэл Францад л биш гэж тэр дүгнэлээ. Энэ салбарт Герман улс манлайлж байгаа нь тодорхой аж. Харин боловсон хүчнээр сайтар хангагдсан үйлдвэрүүдэд нь тоогдох амаргүй. Тиймээс бэлтгэлээ базаахын тулд Фордын Кёльн дахь салбарт ажиллалаа.

Автомашины аварга мангас Фольксвагенд зүтгэж болмоор санагдав. Концерний эрдэмтний дадлаар нэгд нэгэнгүй судалсны эцэст бууралтад автсан аваргыг өөд нь татах тодорхой концепци боловсрууллаа. Үйлдвэрлэлийн зардлыг багасгаж, үр ашгийг нэмэгдүүлэх, роботжуулалт, автоматжуулалт, компьютержүүлэлтийг өргөн нэвтрүүлэх, экологид нийцсэн технологийг эрхэмлэх, Дорнод Европын зах зээл рүү чиглэх гэхчилэн 25 супер зүйлийг багтаасан, нэг хөөрхөн ном бичээд ирж. Чадалтай кадр эрэлхийлж байсан Фольксвагений баяссан гэж. Гюдеверийг бүр ерөнхий менежер болгочихлоо. Ийм хурдан дэвшсэн хүнийг авто ертөнцөд олох аргагүй. Тэгээд бас герман машины үйлдвэрийг франц хүн удирдана гэдэг. Юуны өмнө сонгодог загвар олхоосоо салах болжээ гэж мэдэгдэв. Фольксвагенчууд эмзэглэн шаналсан ч зөвшөөрөв. Битл уг нь концерний бэлгэдэл. Гэхдээ загварыг нь 1931 онд Порше зохиосон шүүдээ. Сүүлийн үед Цохын гүйлгээ эрс унасан. Эндхийн нөхдийн гаргаж зүрхлэхгүй байсан шийдвэрийг франц эр гүйцэлдүүлж чадлаа. Битлээс салснаар үйл ажиллагааны өргөн эрх чөлөө цэлийв. Шинэ Цох бүтээхийг конструкторын хэлтэст даалгаснаар бэлгэдлийн талынхан ч тайвшрав. Өндөр шинэ Цох моодны, үнэтэй машины нэг билээ. Баруун Европод гааль үгүй болсноор авто бүтээгдэхүүний үнэ ялгүй багасч, өрсөлдөгчдийн тэмцэл

ширүүснэ. Үүнийг амжилттай угтахын тулд 30 тэрбум маркийн хөрөнгө оруулалттай 5 жилийн төлөвлөгөө гаргав. Заводууд хий үзэгдэл мэт болж хувирлаа. Цехүүдэд бараг хүн үгүй, тусгаарлагдсан өрөөнд оператор товч дараад л бүх ажиллагааг удирдана. 4 давхар байшин шиг өндөр пресс электрон пультийн тушаалд дуулгавартай нь аргагүй захирагдана. Роботууд бүх гагнуурыг хийж, кузов будаж, угсралтыг гүйцэтгэнэ. Техникийн дэвшил цомхотголд хүргээгүй юм. Ажилчдад оюун, чадвар шаардсан үүрэг оноожээ. Ингэснээр робот, компьютер, автоматжилтаар шүдээ хүртэл зэвсэглэсэн тэдний бүтээмж хэд дахин нэмэгдэв. Үйлдвэрлэлийн өртөг ч багасч, борлуулалт өсөв.

90-ээд онд экологист, экономист чанаруудыг чухал үзүүлэлт гэж тооцно хэмээн Гюдевер тооцоолжээ. Гольф, Этта загваруудад катализатортой дизель хөдөлгүүр суулгаж, утааны хорт бодисыг эрс багсгалаа. Фольксвагений машинууд орчин тойронд муу нөлөө үзүүлэхгүй байх талаараа манлайлж эхлэв. Мөн хэмнэлттэй загварууд нь алдаршив. 120 морины хүчтэй, цагт 200 км хурдаддаг Ауди 100 100 км-т 4,5 литр дизель түлш хэрэглэдэг аж. Гюдеверийн өөрчлөн байгуулалт үүгээр төгссөнгүй. Тэрбээр ЗХУ задарна, Берлиний хана нурна гэж хамгийн түрүүнд мэдсэн хүний нэг юм. Тиймээс үйл явдалд эртнээс бэлтгэж байсан агаад, 1990 онд Зүүн Герман, Польш, Ушарт салбар үйлдвэрийнхээ тулгын чулууг тавин. Мөн Зүүн Германы Вартбург, Трабант, Чехийн Шкодаг худалдан авлаа. 1992 онд Украин, Орост угсрах заводаа барьж эхлэв. Ийнхүү Дорнод Еиropyн зах зээл рүү эрчимтэй довтоллоо. Хятадад мөн хоёр завод барьсан юм. Ер нь Фольксвагений жижиг салбарууд даян дэлхийгээр нэг тарсан байдаг. Мост, тормоз, жолооны удирдлага, зангилаанууд Брауншвейгээс, хурдны хайрцаг Касселиэс, мотор Зальцгиттерээс, дуу намсгагч Словениэс, арын мост Мексикээс, гэрэл Австриас, дугуйны диск Канадаас ирдэг.

Гюдеверийг ирснээс хойш Фольксваген хөнгөн тэргийн үйлдвэрлэлээр дэлхийд 4-рт орох болжээ. Жилд концерн 3-3,5 сая автомашин худалддаг. Европод хамгийн олон хөнгөн тэрэг борлуулдаг фирм бол Фольксваген юм. Энд зарагддаг суудлын авто машины 15 хувь нь Фольксвагенийх билээ.

Ийм амжилтад хүргэсэн мань хүнийг Фольксвагений ерөнхий захирал болгон дэвшүүлжээ. Хичээнгүй зан, уйгагүй хөдөлмөрөөрөө цомхотголд орсон багш үнэмшиггүй амжилтад хүрчээ. Тэр концерний акцийн 20 хувийг эзэмшдэг. Гурван тансаг харштай, хуучны хөнгөн тэргийн цуглуулгатай юм. Вольфсбургэд тэр хайр дурлалтайгаа учирсан агаад, өөрөөс нь 23 дүү, үзэсгэлэнт герман бүсгүй Фридатай гэрлэжээ. "Миний амжилтын нууц гэвэл эрхэлсэн ажлаа үнэн голоосоо сонирхдог явдал юм" гэж Гюдевер энгийнээр тайлбарлажээ. Сүүлийн үед Ауди 100 ТДИ загварыг худалдаанд гаргаад байна. Энэ машины хөдөлгүүр супер хэмнэлт үзүүлдгээрээ онцлогтой. Хурдны замаар давихад 100 км-т 1,5 литр түлш зарцуулна. Удалгүй 1 литр зарцуулдаг болно. Дизель түлш хорт бодис их ялгаруулдаг. Гэтэл ТДИ-гийн утаанд Европын хамгийн цэвэр автомашин болох бензин хөдөлгүүрт Фольксваген Гольфынхоос дахин бага хорт бодис илэрдэг аж. ТДИ-гийн АУК, нам чимээт чанар нь бензин хөдөлгүүрээс сайн юм. Гюдевер ТДИ - г миний дэвшүүлсэн концернийн хамгийн шилдэг биелэл хэмээжээ. Ийнхүү Фольксваген авто үйлдвэрлэлд ид хаваа гайхуулсаар байна.